

**НИЙСЛЭЛИЙН СУХБААТАР ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 10, 17 дугаар зүйлийг үндэслэн Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамжийн хэлтсийн даргын албан тушаалын сонгон шалгаруулалтыг /өмнө нь зарлаад хойшилсон/-ыг 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс ажлын 7 хоногийн хугацаатай зарлаж байна.

Сонгон шалгаруулалтад оролцох иргэн нь Төрийн албаны тухай хуулийн 10.1-д заасан өрөнхий шаардлага болон томилох эрх бүхий этгээдийн баталсан ажлын байранд тавигдах дараах шаардлагыг хангасан байна.

Тухайн ажлын байранд тавигдах шаардлага:

| | Чухал шаардлагатай | Шаардлагатай |
|------------------|---|--|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй | Магистр |
| Мэргэжил | Эрх зүйч, зэдийн засаг, багш, нийгмийн ажилтан | Нягтлан бодох бүртгэл |
| Мэргэшил | Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, хүний нөөц, нийгмийн удирдлагын чиглэлээр сургалтад хамрагдсан байх | Төрийн албаар мэргэшсэн байх |
| Туршлага | Улсад 5-аас дээш жил ажилласан байх | Улсад 3-аас доошгүй жил ажилласан байх |
| Үр чадвар | Удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах, хүнийг хөгжүүлэх, баг бүрдүүлж ажиллах, баримт бичиг боловсруулах, хариуцлага хүлээх, харилцааны соёлтой байх, монгол хэл бичгийн дүрэм, найруулга, албан хэрэг хөтлөлтийн талаар мэдлэг, үр чадвартай байх | Компьютерийн өргөн хэрэглээний программ ашиглах, дотоод гадаад сүлжээнээс мэдээлэл авах, илгээх чадвартай байх |
| Тусгай шаардлага | -Ес зүйн хэм хэмжээг чанд сахих, авлигаас ангид ажиллах | |

Сонгон шалгаруулалтыг 2017 оны 04 дүгээр сарын 27,28-ны өдөр зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтын бүртгэл:

Сонгон шалгаруулалтад орох иргэний баримт материалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 106 тоот өрөөнд 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 09.00-12.30, 13.30-17.00 цагуудад хүлээн авч, бүртгэнэ. Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэн дор дурьдсан материалыг бүрдүүлэн өөрийн биеэр ирж бүртгүүлнэ. Үүнд:

29. Төрийн албан хаагчийн анкет (маягт №1);
30. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эхийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;
31. Иргэний үнэмлэх;
32. Ажилласан жилийг тооцох хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эх хувийн хамт;
33. Ажил байдлын тодорхойлолт;
34. 4x3 хэмжээтэй 2 хувь цээж зураг;
35. Шалгалтын үйлчилгээний төлбөр 10000 төгрөг.

Дээрх баримт бичгийг дутуу бүрдүүлсэн иргэнийг бүртгэхгүй.

3. Сонгон шалгаруулалтыг Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам", Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 14 дүгээр тогтоолоор баталсан зааврын дагуу зохион байгуулна.

Ажлын байранд тавигдах шаардлага, бүрдүүлэх материалын талаар Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn, яамны www.mlsp.gov.mn цахим хуудаснаас танилцах боломжтой.

ХАРИЛЦАХ УТАС: 262621

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗОВЛОЛ